

*Барилга, Дэд Бүтцийн Олон Улсын Арбитрын Удирдах Зөвлөлийн*

*... оны ... дугаар сарын ...-ний өдрийн*

*... тоот тогтоолын Хавсралт*

**МОНГОЛЫН БАРИЛГА, ДЭД БҮТЦИЙН  
ОЛОН УЛСЫН АРБИТРЫН ТӨВИЙН  
ДҮРЭМ**

**(Анхны хувилбар, 2024 он,  
Улаанбаатар хот)**

**МОНГОЛЫН БАРИЛГА, ДЭД БҮТЦИЙН ОЛОН УЛСЫН АРБИТРЫН ТӨВИЙН ДҮРЭМ**

## **НЭГ. МОНГОЛЫН БАРИЛГА, ДЭД БҮТЦИЙН ОЛОН УЛСЫН АРБИТР, ТҮҮНИЙ ЧИГ ҮҮРЭГ**

- 1.1. Монголын Барилга, Дэд Бүтцийн Олон Улсын Арбитрын Төв /цаашид “арбитр” гэх/ нь арбитрын ажиллагааг хараат бус, бие даасан байдлаар явуулах байнгын арбитр мөн. Уг арбитрын төвийн хяналт, удирдлагын чиг үүргийг Барилга, Дэд Бүтцийн Олон Улсын Арбитрын Удирдах Зөвлөл (цаашид “Удирдах Зөвлөл” гэнэ) хэрэгжүүлэнэ.
- 1.2. Арбитр нь өөрийн салбарыг гадаад улсад болон Монгол Улсын аймагт байгуулж болох бөгөөд тэдгээрийг зохион байгуулалт, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.
- 1.3. Арбитр дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:
  - 1.3.1. Монгол Улсад маргаан шийдвэрлэх сонголтот арга болох арбитр, эвлэрүүлэн зуучлалын ажиллагааг дэмжиж, олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх;
  - 1.3.2. арбитрын хэлэлцээр, харьяалал бүхий маргааныг хянан шийдвэрлэх;
  - 1.3.3. арбитрын ажиллагааны талаар судалгаа хийх, сургалт зохион байгуулах, арбитрчдыг мэргэшүүлэх;
  - 1.3.4. арбитрыг Удирдах Зөвлөлийн гишүүн, хөрөнгө оруулагч, аж ахуй эрхлэгч, олон нийтэд таниулан сурталчлах, энэ зорилгоор танилцуулга, гарын авлага, ном гаргах, соён гэгээрүүлэх ажил явуулах;
  - 1.3.5. олон улсын арбитрын төвүүдтэй ажил хэрэгч харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх;
  - 1.3.6. арбитрын ажиллагааны нууцыг хадгалж, арбитрын ажиллагааг хараат бус, шударга, шуурхай явуулах.
- 1.4. Арбитрын оршин байрлах газар нь Улаанбаатар хот, ... дүүрэг ... дугаар хороо, ... гудамж, Барилга, Дэд Бүтцийн Олон Улсын Арбитрын байр байна.
- 1.5. Арбитр нь өөрийн бэлгэ тэмдэг, тамга, түг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд банкинд төгрөгийн болон валютын харилцах данстай байна.
- 1.6. Арбитр нь ашиг орлого олох зорилгоор аж ахуйн үйл ажиллагаа явуулахгүй боловч Монгол Улсын Арбитрын тухай хууль, энэхүү дүрэмд заасан зорилгын хүрээнд хуулиар хориглоогүй үйлчилгээ үзүүлж, өөрийгөө санхүүжүүлнэ.

### **ХОЁР. АРБИТРЫГ БАЙГУУЛАХ, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

- 2.1. Удирдах Зөвлөл нь арбитрын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
  - 2.1.1. арбитрыг байгуулах, татан буулгах, арбитрын дүрмийг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах;
  - 2.1.2. арбитрын дарга, ерөнхий нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны даргыг томилох, чөлөөлөх;
  - 2.1.3. арбитрын арбитрчийн нэрсийн жагсаалтыг батлах, өөрчлөх;
  - 2.1.4. арбитрын жил бүрийн төсөв, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэж, батлах.
- 2.2. Арбитр нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон санхүүгийн хувьд бие даасан, хараат бус ажиллах нөхцөлийг хангах талаар Удирдах Зөвлөл болон түүний салбар Удирдах Зөвлөл бүх талын дэмжлэг үзүүлнэ.
- 2.3. Арбитр нь бүтэц, зохион байгуулалтын хувьд дараах бүрэлдэхүүнтэй байна:

- 2.3.1. арбитрын дарга;
  - 2.3.2. арбитрын ерөнхий нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга;
  - 2.3.3. арбитрчид;
  - 2.3.4. арбитрчдын зөвлөл;
  - 2.3.5. нарийн бичгийн дарга, мэргэжилтэн;
  - 2.3.6. орон тооны бус хороод.
- 2.4. Арбитрын дарга, түүний бүрэн эрх
- 2.4.1. Арбитрын ажиллагааны дадлага туршлагатай, бизнесийн болон хууль зүйн салбарт удирдах албан тушаал эрхэлж байсан, нэр хүндтэй, эрх зүйч мэргэжилтэй хүнийг арбитрын даргаар Удирдах Зөвлөлөөс томилно.
  - 2.4.2. Арбитрын дарга нь хууль, арбитрын хэрэг хянан шийдвэрлэх журам болон энэхүү дүрэмд заасан бүрэн эрхийн хүрээнд шийдвэр гаргах бөгөөд шийдвэрийн хэлбэр тушаал хэлбэртэй байна.
  - 2.4.3. Арбитрын дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
    - 2.4.3.1 арбитрыг гадаад, дотоодод итгэмжлэлгүй төлөөлөх, гэрээ хэлцэл, санамж бичиг байгуулах;
    - 2.4.3.2 арбитрын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор бодлого боловсруулах, арбитрын үйл ажиллагааг сурталчлах, төлөвлөгөө гаргах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
    - 2.4.3.3 арбитрын жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Удирдах Зөвлөлд тайлагнах;
    - 2.4.3.4 арбитрын жил бүрийн төсвийг боловсруулж, Удирдах зөвлөлөөр батлуулах, төсвийг захиран зарцуулах;
    - 2.4.3.5 арбитрчийн нэрсийн жагсаалт болон жагсаалтад нэмэх, хасах саналыг Удирдах Зөвлөлөөр батлуулах;
    - 2.4.3.6 салбар арбитрын арбитрчийн нэрсийн жагсаалтыг батлах;
    - 2.4.3.7 ерөнхий нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга болон арбитрчдын гаргасан санал хүсэлтийг шийдвэрлэх;
    - 2.4.3.8 арбитрын тухай хууль болон арбитрын хэрэг хянан шийдвэрлэх журамд заасан эрх хэмжээний хүрээнд арбитрын ажиллагаанд оролцож, шийдвэр гаргах;
    - 2.4.3.9 хууль, дүрэмд зааснаас бусад тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй.
- 2.5. Арбитрын ерөнхий нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга, түүний эрх, үүрэг
- 2.5.1. Ерөнхий нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны даргаар Арбитрын ажиллагааны дадлага туршлагатай, бизнесийн болон хууль зүйн салбарт удирдах албан тушаал эрхэлж байсан, нэр хүндтэй, эрх зүйч мэргэжилтэй хүнийг Удирдах Зөвлөлөөс томилно.
  - 2.5.2. Ерөнхий нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга дараах үндсэн 2 чиг үүргийн хүрээнд ажиллана:

а / арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэвийн байдлыг хангаж нарийн бичгийн дарга нарыг удирдлагаар хангах;

б/ ажлын албаны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах.

2.5.3. Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэвийн байдлыг хангах хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.5.3.1. хэргийн бүртгэлийг зохион байгуулах;

2.5.3.2. нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, бүрдүүлбэрийг хянах, буцаах;

2.5.3.3. хэрэг үүсгэн, хэргийн дугаар олгох;

2.5.3.4. хэргийг нарийн бичгийн дарга нарт хуваарилах;

2.5.3.5. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шуурхай байдлыг хангаж нарийн бичгийн дарга нарт үүрэг даалгавар өгөх;

2.5.3.6. арбитрын бүрэлдэхүүнээс гаргасан арбитрын хэрэг шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хүсэлтийг шийдвэрлэх;

2.5.3.7. арбитрын хэрэг шийдвэрлэх ажиллагааны процесстой холбогдуулан арбитрын бүрэлдэхүүнд санал, зөвлөмж өгөх.

2.5.4. Арбитрын ажлын албаны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах чиг үүргийн хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.5.4.1. арбитрын үйл ажиллагааг тасралтгүй хөгжүүлэх, бэхжүүлэх, сурталчлах чиглэлээр бодлого боловсруулж ажиллах;

2.5.4.2. арбитрын ажиллагааг хэвийн явуулах нөхцөл боломжоор хангах;

2.5.4.3. Арбитрын эд хөрөнгө, тоног төхөөрөмжийн эзэмшил, ашиглалтыг удирдан зохион байгуулах;

2.5.4.4. эрдэм шинжилгээ, судалгааны ажил, гадаад дотоод хамтын ажиллагааг хариуцан ажиллах;

2.5.4.5. арбитрчид болон нарийн бичгийн дарга нарыг сургах, давтан сургах ажлыг зохион байгуулах;

2.5.4.6. арбитрын даргын эзгүйд түүний эрх үүргийг хэрэгжүүлэх;

2.5.4.7. арбитрын даргын эрх олгосноор гадаад дотоодод төлөөлөх, хамтын ажиллагааг өргөжүүлэх;

2.5.4.8. арбитрын хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал, зөвлөмж гаргах;

2.5.4.9. арбитрчдын сангийн жил бүрийн төсвийн гүйцэтгэлийг арбитрчдын зөвлөлд тайлагнах;

2.5.4.10. батлагдсан төсөвт нийцүүлэн ажлын албаны орон тоо, бүтэц, ажилтны ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг батлуулах буюу нэмэлт өөрчлөлт оруулахаар арбитрын даргад танилцуулах;

2.5.4.11. арбитрын нарийн бичгийн дарга, ажлын албаны мэргэжилтэн, ажилтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, ажилд авах буюу ажлаас чөлөөлөх үндэслэлтэй саналыг арбитрын даргад хүргүүлэх;

- 2.5.4.12. хууль, дүрэмд зааснаас бусад тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй.

### **ГУРАВ. АРБИТРЧИД**

- 3.1. Удирдах Зөвлөлийн тогтоолоор арбитрчийн нэрсийн жагсаалтад орсноор арбитрч нь арбитрын хэрэг шийдвэрлэх ажиллагаанд сонгогдох, томилогдох эрхтэй болно. Арбитрчдын танилцуулгыг нийтэд мэдээлнэ.
- 3.2. Арбитрын арбитрч орон тооны бус байх бөгөөд дараах шалгуурыг хангасан байна:
- 3.2.1. өөрийн мэргэжлийн салбартаа мэргэшсэн, хүлээн зөвшөөрөгдсөн байх бөгөөд хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг мэргэжил, мэргэшил, эрдмийн зэрэг цол, эрдэм шинжилгээний бүтээл, хуульд заасан бол тухайн салбарын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, үр чадварыг илтгэх бусад баримтыг үндэслэж тодорхойлно;
  - 3.2.2. эрүүгийн ял шийтгэл эдэлж байгаагүй, мэргэжлийн болон ёс зүйн аливаа зөрчил гаргаж байгаагүй, 35-с дээш 70 хүртэлх насны гадаад, дотоодын иргэн байх;
  - 3.2.3. арбитрын сургалтын болон мэргэшлийн хорооны сургалтад хамрагдаж, сонгон шалгаруулалтад тэнцсэн байх;
  - 3.2.4. өөрийн ажиллаж байгаа ажил, албан тушаал нь арбитрчаар ажиллахад харшлахгүй байх;
  - 3.2.5. арбитрчаар томилогдсон тохиолдолд хэргийг хянан шийдвэрлэхэд цаг зарцуулах, шударга, хэргийг хараат бус, бие даасан байдлаар шийдвэрлэх;
  - 3.2.6. арбитрын ажиллагаа болон хуралдааныг хууль, дүрмээр тогтоосон цаг хугацаанд удирдан явуулах, шийдвэрээ үндэслэлтэй гаргах, арбитрын шийдвэрийг ойлгомжтой, алдаагүй бичиж гаргах чадвартай байх;
  - 3.2.7. Монгол Улсын бусад байнгын арбитрын арбитрчийн нэрсийн жагсаалт буюу бүрэлдэхүүнд харъяалагддаггүй байх.
- 3.3. Арбитрчийн нэрсийн жагсаалтад орох хүсэлт гаргасан иргэдийн хүсэлт, мөн арбитрчийг нэрсийн жагсаалтаас хасах, түдгэлзүүлэх, улируулан сонгох асуудлыг арбитрчдын зөвлөлөөр хэлэлцүүлэн Удирдах Зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлнэ.
- 3.4. Арбитрч эрх үүргээ хэрэгжүүлэхдээ мэдээллийн нууцыг хадгалах үүрэгтэй бөгөөд арбитрчийн ёс зүйн дүрмийг чандлан сахина.
- 3.5. Арбитрчийн нэрсийн жагсаалтаас хасах шийдвэр гаргасан нь арбитрын ажиллагаа явагдаж буй хэрэг хянан шийдвэрлэх арбитрын бүрэлдэхүүнд томилогдон ажиллаж буй арбитрчийн бүрэн эрх, ажиллах нөхцөлд тухайн хэрэг хянан шийдвэрлэгдэж дуусах хүртэл ямар нэг нөлөө үзүүлэхгүй.
- 3.6. Арбитрчийг арбитрчдын нэрсийн жагсаалтад орох хүсэлт, жагсаалтаас хассан, түдгэлзүүлсэн, удирдах зөвлөлийн шийдвэр нь эцсийн бөгөөд энэ талаар аливаа гомдол гаргах эрхгүй.
- 3.7. Арбитрч нь дараах эрх эдэлнэ:
- 3.7.1. арбитрчаар сонгогдох, томилогдох, татгалзах;
  - 3.7.2. хэргийн материалтай танилцах, энэ талаар мэдээлэл авах;

- 3.7.3. арбитрын ажиллагааг шуурхай явуулах талаар санал гаргах, нарийн бичгийн даргад үүрэг өгөх, ерөнхий нарийн бичгийн даргад хүсэлт гаргах;
- 3.7.4. арбитрчдын зөвлөлийн бүрэлдэхүүнд нэрээ дэвшүүлэх эрхтэй;
- 3.7.5. арбитрчийн урамшуулал авах.
- 3.8. Арбитрч нь дараах үүрэг хүлээнэ:
  - 3.8.1. арбитраас зохион байгуулж буй үйл ажиллагаанд оролцох;
  - 3.8.2. арбитрын хэрэг шийдвэрлэх ажиллагааны талаар сургалтын хорооны давтан сургалтад жилд 1 удаа хамрагдах;
  - 3.8.3. бүрэлдэхүүнд нь орсон арбитрын хэргийн ажиллагаанд идэвхитэй, санаачлагатай, шуурхай ажиллаж, цаг заваа зориулах;
  - 3.8.4. арбитрын ажиллагаанд хараат бус, бие дааж оролцох;
  - 3.8.5. арбитрын ажиллагааны нууцлалыг хадгалах;
  - 3.8.6. бусад.
- 3.9. Хэрэг хянан шийдвэрлэх арбитрын бүрэлдэхүүнд орсон арбитрч нь тухайн маргааны талууд болон тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчдөд өмнө нь мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээ үзүүлж байгаагүй, тэдгээртэй төрөл садангийн болон ажил үүрэг, эд хөрөнгийн хувьд холбоогүй, ашиг сонирхлын зөрчилгүй байна.
- 3.10. Арбитрчдын нэрсийн жагсаалтаас арбитрчийг дараах тохиолдолд хугацаанаас нь өмнө чөлөөлнө:
  - 3.10.1. эрх зүйн чадамжгүй болсон;
  - 3.10.2. арбитрчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн;
  - 3.10.3. авилга, хээл хахууль авсан нь нотлогдсон;
  - 3.10.4. арбитрын нэр хүндийг унагаах, буруугаар ашиглах үйлдэл гаргасан;
  - 3.10.5. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илтэд идэвхгүй оролцсон;
  - 3.10.6. дүрэмд заасны дагуу 70 нас хүрсэн;
  - 3.10.7. арбитрчаар ажиллахад харшлах өөр ажил, албан тушаалд томилогдсон;
  - 3.10.8. өөрөө хүсэлтээ гаргасан;
  - 3.10.9. нас барсан;
  - 3.10.10. арбитрын сургалтын хорооны жил бүрийн давтан сургалтанд хамрагдаагүй.

#### **ДӨРӨВ. АРБИТРЧДЫН ЗӨВЛӨЛ**

- 4.1. Арбитр нь арбитрын дарга, ерөнхий нарийн бичгийн дарга, арбитрчдын төлөөллөөс бүрдсэн арбитрчдын орон тооны бус зөвлөлийг ажиллуулна.
- 4.2. Арбитрчдын зөвлөл нь 7 гишүүнтэй байх бөгөөд арбитрын дарга, ерөнхий нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга зөвлөлийн бүрэлдэхүүнд орно. Үлдэх 5 гишүүнийг 3 жилийн хугацаагаар арбитрын дарга томилно.
- 4.3. Арбитрчдын зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр хуралдаан байх бөгөөд асуудлыг олонхийн зарчмаар шийдвэрлэх ба шийдвэрлэсэн асуудлаар тогтоол гаргана.
- 4.4. Арбитрчдын зөвлөлийн даргыг гишүүд дундаасаа олонхийн саналаар 3 жилийн хугацаатай томилно.

4.5. Арбитрчдын зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 4.5.1. арбитрын үйл ажиллагаа, зорилго, зорилт, бодлогыг тодорхойлох, арбитрыг төсөв санхүүгийн талаар бэхжүүлэхэд арбитрчдын оролцоог хангах;
- 4.5.2. арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийг батлах, өөрчлөх, хүчингүй болгох;
- 4.5.3. арбитрчдыг мэргэшүүлэх, давтан сургалтын хөтөлбөр батлах;
- 4.5.4. арбитрчдын ёс зүйн дүрмийг батлах, өөрчлөх, арбитрчдын ёс зүйн талаарх гомдол өргөдлийг хэлэлцэх, арбитрчдад ёс зүйн шийтгэл оногдуулах;
- 4.5.5. арбитрчдын сангийн жилийн төсвийг батлах, захиран зарцуулалтад хяналт тавих;
- 4.5.6. арбитрчийн нэрсийн жагсаалтад орох хүсэлтэй иргэдийн санал хүсэлтийг хуралдаанаар хэлэлцэн Удирдах Зөвлөлд оруулах эсэх талаар шийдвэр гаргах;
- 4.5.7. байнгын арбитраас түр арбитрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх тухай дүрмийг батлах, өөрчлөх;
- 4.5.8. Удирдах Зөвлөл шийдвэрлэхээс бусад асуудлыг бие даан шийдвэрлэх, батлах.

**ТАВ. АЖЛЫН АЛБА**

- 5.1. Арбитрын ажлын алба нь ерөнхий нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга, хуралдааны нарийн бичгийн дарга, мэргэжилтнээс бүрдэнэ.
- 5.2. Арбитрын хуралдааны нарийн бичгийн дарга нь эрх зүйч мэргэжилтэй байх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
  - 5.2.1. ерөнхий нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны даргаас хуваарилсан арбитрын хэргийг хүлээн авч арбитрын ажиллагааг эхлүүлэх ажиллагааг шуурхай явуулах;
  - 5.2.2. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуралдааны нарийн бичгийн даргаар ажиллах;
  - 5.2.3. хэргийг илтгэх, хуралдааны бичлэг хийх, тэмдэглэл хөтлөх;
  - 5.2.4. арбитрын бүрэлдэхүүн болон талуудыг хэргийн талаарх мэдээллээр хангах;
  - 5.2.5. арбитрын ажиллагааны бэлтгэл хангах, зохион байгуулалт хийх;
  - 5.2.6. ерөнхий нарийн бичгийн дарга буюу ажлын албаны даргад арбитрын процесс ажиллагааны талаар шуурхай мэдээлж, дэмжлэг түслэмж авах;
  - 5.2.7. арбитрын бүрэлдэхүүнээс өгсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэх;
  - 5.2.8. арбитрын ажиллагааны нууцыг чандлан хадгалах;
  - 5.2.9. бусад
- 5.3. Арбитрын мэргэжилтэн нь арбитрын хэвийн үйл ажиллагааг хангах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
  - 5.3.1. үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, маркетинг, хүний нөөц, эд хөрөнгийн ашиглалт, захиран зарцуулалт;
  - 5.3.2. гадаад, дотоод хамтын ажиллагаа;
  - 5.3.3. судалгаа, шинжилгээ, сургалт;
  - 5.3.4. мэдээлэл зөвлөгөө, үйлчилгээ.

## **ЗУРГАА. САНХҮҮ, ТӨСӨВ**

- 6.1. Арбитрын төсөв дараах эх үүсвэрээс бүрдэнэ:
  - 6.1.1. арбитрын ажиллагааны үндсэн ба нэмэлт зардал;
  - 6.1.2. иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хандив;
  - 6.1.3. сургалт, семинар зохион байгуулах болон хэвлэн нийтлэх үйл ажиллагаанаас олсон орлого;
  - 6.1.4. арбитрыг хөгжүүлэх дэмжлэгийн арга хэмжээ, төслийн үйл ажиллагааны орлого;
  - 6.1.5. хуулиар зөвшөөрсөн, арбитрын үйл ажиллагааны үндсэн зарчимд нийцсэн бусад орлого;
  - 6.1.6. Удирдах Зөвлөлөөс арбитрын үйл ажиллагааг дэмжиж шилжүүлсэн орлого, эд хөрөнгө.
- 6.2. Арбитр нь орлогоо зөвхөн дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулна.

## **ДОЛОО. БУСАД**

- 7.1. Арбитр нь Удирдах Зөвлөлийн дэргэдэх ...-ын эрх залгамжлагч байгууллага мөн.
- 7.2. Арбитрын үйл ажиллагааг зогсоох, татан буулгах асуудлыг Удирдах Зөвлөл шийдвэрлэнэ.
- 7.3. Арбитр нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэвийн байдлыг хангах үүднээс холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.
- 7.4. Арбитр захиргааны болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэвийн байдлыг хангах зорилгоор аливаа дүрэм, дотоод журмыг баталж үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.
- 7.5. Арбитр нь Монгол Улсад арбитрыг хөгжүүлэх, сурталчлах, хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор гадаад, дотоодын байгууллага, арбитр, холбоодтой хамтран ажиллах, гэрээ, хэлцэл, санамж бичиг байгуулах болон гишүүнээр элсэж болно.
- 7.6. Энэхүү дүрмийг ... оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.